

2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2026-05-11

Өндөртөлгой

Нийслэл, дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-11, 12 фонтоор бичиж, **2026 оны 05 дугаар сарын 19-ний “Мягмар” гарагт 12.00 цагт Засаг даргын Тамгын газрын холбогдох бодлогын хэлтэст албан бичгээр, Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд 16.00 цагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Эрх зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн (ERP Н.Батцэнгэл)-д word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлэхдээ Нийслэлийн Хяналт-шинжилгээ үнэлгээний газраас ирүүлсэн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 2025 оны 44 дүгээр зөвлөмжийн дагуу дараах шаардлагыг ханган тайлагнаж ажиллана уу.

1. Хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах, үйл ажиллагааны явц бус гарц, үр дүнг тайлагнах.

2. Үүргийн биелэлтийг тогтоосон хугацаанд, нотлох баримтын хамт, бүрэн гүйцэд тайлагнах.

3. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага бус үндсэн буюу бодлого хэрэгжүүлэгч байгууллага нэгтгэн тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1.	Засгийн газрын 2026 оны “Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах.	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс
2.	Засгийн газрын 2026 оны 16 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу Улаанбаатар хотод сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэр бүхий цахилгаан тээврийн хэрэгслийн цэнэглэх дэд бүтцийг байгуулах боломжит цэгүүдийн судалгааг боловсруулж, үр дүнг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах.	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
3.	НИТХ-ын 2025 оны 25/29 дүгээр тогтоолоор баталсан “Худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам”-ын өөрчлөлтийг яаралтай боловсруулж, танилцуулах.	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
4.	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Чөлөөлье” санаачилгын хүрээнд зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулах, нэгдсэн удирдлагад шилжүүлсэнтэй холбогдуулан хуучин “Онлайн бизнес төв” системээр худалдаа, үйлчилгээ эрхлэхээр ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдвэрлэх.	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
5.	“Зөвшөөрлийн нэгдсэн сан” цахим системийн ашиглалтын талаар Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран холбогдох байгууллагуудын албан хаагчдад сургалт зохион байгуулах.	Тамгын газрын дарга, Төрийн захиргааны удирлагын хэлтэс
6.	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Чөлөөлье” санаачилгын хүрээнд зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулах, нэгдсэн удирдлагад шилжүүлсэнтэй холбогдуулан тус үйлчилгээг жигдрэх хугацаанд 7 хоног бүрийн 5 дахь өдөр Захирагчийн ажлын алба тайланг	Тамгын газрын дарга, Төрийн захиргааны удирлагын хэлтэс

	танилцуулах.	
7.	Нийслэлийн хэмжээнд тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, орон сууцны хороолол дундах хог хаягдлыг цэвэрлэх, тээвэрлэх ажлыг эрчимжүүлэх.	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
8.	Нийгмийн салбарт хийгдэж буй ажлууд болон 2027-2028 онд тус салбарыг хөгжүүлэх зорилтыг боловсруулж, танилцуулах.	Засаг даргын орлогч, Нийгмийн хөгжлийн хэлтэс
9.	Нийслэлийн хэмжээнд худалдан авах ажиллагаа болон гэрээ байгуулах ажлыг эрчимжүүлж ажиллах.	Санхүү төрийн сангийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны алба
10.	Дараах ажлуудыг нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулах. Үүнд: Багахангай үйлдвэрлэл технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил зэргийг танилцуулах.	Дүүргийн менежер, Багахангайн Үйлдвэр технологийн парк ХК
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
11.	Газрын зөрчлүүдийг бүрэн арилгуулахад онцгойлон анхаарч, холбогдох хууль, журмын хүрээнд шаардлагатай арга хэмжээг авч ажиллах	Газар зохион байгуулалтын алба, Холбогдох ажлын хэсэг
12.	Нийслэлийн Засаг даргын 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангуулж, илэрсэн зөрчлүүдийг бүрэн арилгуулан ажиллах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Холбогдох ажлын хэсэг
13.	Төсвийн орлогыг жигд ханган биелүүлэх	Санхүү төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс
14.	Хөрөнгө оруулалтын ажлын хяналтыг сайжруулах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Холбогдох ажлын хэсэг
15.	Бүх нийтийн мод тарих өдрийн бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
16.	Улирлын чанартай худалдаа, үйлчилгээний цэгүүдийн гадна тохижилтыг орчны стандарт, шаардлагад нийцүүлэн сайжруулах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
17.	Зам засварын ажлын талаарх холбогдох мэдээллийг шуурхай авч, засварын ажлыг эхлүүлэх	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
18.	3, 4, 5 дугаар байрнуудын босоо шугам солих ажлын бэлтгэл ажлыг бүрэн хангаж, ажлыг эхлүүлэх, иргэдэд холбогдох мэдээллийг тухай бүр хүргэж ажиллах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, СӨХ
19.	Эрчим хүчний яамтай уулзах уулзалтын товыг тодруулах, уулзалтад оролцох	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
20.	Нийтийн эзэмшлийн талбайд түүвэр цэвэрлэгээг тогтмол хийж, тоосжилт үүссэн талбайг чийгшүүлэх арга хэмжээг авах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
21.	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, зорилтот жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажиллах	Нийт байгууллагууд
22.	Төсвийн тодотголд бэлтгэх	Санхүү төрийн сангийн хэлтэс
23.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах сургалтад хамрагдах	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Нийт байгууллагууд
24.	В1 давхрын цонхны эвдрэл, гэмтэлд хяналт тавих, засварлуулах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
25.	Хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах	Нийгмийн хөгжлийн хэлтэс

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

МЭРГЭЖИЛТЭН

Н.БАТЦЭНГЭЛ